



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар Б/23

Баян-Овоо сум

Ж.Цагаачинг ажилд томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Засгийн газрын 2024 оны 128 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт, (сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ)-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага ангийн багш дутагдалтайг харгалзан Жигжидийн Цагаачинг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн бага ангийн багшийн үүрэгт ажилд томилсугай.

2. Ж.Цагаачингийн сарын үндсэн цалинг ТҮБД-3 зэрэглэлээр тогтоон 1,484,000 (нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянга) төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д, ажил үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сургалтын менежер (П.Болортуяа)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ *Ч.Болормаа* Ч.БОЛОРМАА

